



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/629

Булган сум

┌ Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн ┐
улсын тооллогыг зохион байгуулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар 16.1.1, 16.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам” батлах тухай А/377 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх, бүрэн бүтэн байдал, бүтэц, шинж чанар, тоо хэмжээг нягтлан шалгаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор дурсгалт зүйлийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийн байр, унааны зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010871